



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/469

Алтай хот

Гэр бүл зохиогоогүй залуучуудын уулзалт,
арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2, 8.1.4 дэх заалт, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэлийн 2 дугаар зүйлийн 2.3.3 дахь хэсэг, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2 дугаар зүйлийн 2.7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Залуучуудын хөгжлийн сарыг угтан гэр бүл төлөвлөлт, хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд, хувь хүний хөгжил, угийн бичиг хөтлөхийн ач холбогдол, амьдрах ухааны сургалт, мэдээлэл олгох зорилгоор гэр бүл зохиогоогүй, ганц бие буюу "Дан гэр бүл" залуучуудын уулзалт, арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 11,12, 13-ны өдрүүдэд зохион байгуулж, зохион байгуулах салбар хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Зохион байгуулах удирдамж, ажлын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулан батлуулж, халдвар хамгааллын дэглэмийг сайтар сахиулан, өндөр түвшинд зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсэг (П.Хулан)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 16-ны өдрийн 1469 дугаар
захирамжийн хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Нэг.Нэгдсэн удирдлагаар хангах баг:

Дарга: П.Хулан (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:Б.Алтайбаатар (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Хоёр. Сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах баг:

С.Цагаанбаатар (Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ж.Амгаланбаатар (Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Ундармаа (Насан туршийн боловсролын төвийн захирал)

М.Мягмарбаяр (Алтай усан спорт чийрэгжүүлэлтийн газрын захирал)

Гурав. Соёл урлаг, спортын үйл ажиллагаа зохион байгуулах баг:

Э.Отгонбаатар (Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
(Аймгийн Залуучуудын холбоо)

Дөрөв. Хэвлэл мэдээлэл, сурталчилгаа, судалгааны баг:

(Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын алба) (зөвшилцсөнөөр)

Т.Эрхэмбаяр (Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн захирал)

Э.Өлзийхишиг (Олон нийтийн Алтай радио, телевизийн төвийн сэтгүүлч)
("Алтайн мэдээ" агентлаг)

Тав. Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, Эрүүл мэндийн урьдчилсан үзлэг зохион байгуулах баг:

Г.Лхагважаргал (Эрүүл мэндийн газрын дарга)

Ш.Мэндсайхан (Нэгдсэн эмнэлгийн дарга)

Р.Наранбаатар (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)